

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.030.50

Хоёрдогч түүхий эд өнгөт төмөрлөгийн Техникийн ерөнхий нөхцөл	MNS 3438:83
Вторичное сыре Лом и отходы цветных металлов, Общие технические условия.	

БНМАУ-ын Үнэ, стандартын улсын хорооны 1983 оны 40 дугаар тогтоолын дагуу 1983 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

### Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

Энэ стандарт нь үйлдвэрлэл, хэрэглээнээс гарсан өнгөт төмөрлөгийн ангилан, ялгаж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар бэлтгэлд хүлээн авах хаяглах тээвэрлэх, хадгалах, хамаарна.

Энэ стандартын үнэт төмөрлөгийн хольцтой өнгөт төмөрлөг үл хамаарна.

### 1 Техникийн шаардлага.

1.1 Хоёрдогч түүхий эдэд зориулан бэлтгэх өнгөт төмөрлөгийн хаягдлыг 1-р хүснэгтэнд дурьдсан нэрээр ангилан бэлтгэнэ.

1-р хүснэгт.

Өнгөт төмөрлөгийн нэр.	Тэмдэглэгээ.
1. Хөнгөн цагаан.	ХЦ
2. Гянтболд.	ГБ
3. Кадмий	КД
4. Кабольт	КБ
5. Магний	МГ
6. Зэс	ЗС
7. Молибден	МБ
8. Диц.	ДЦ
9. Цагаан тугалга.	ЦТ
10. Мөнгөн ус.	МН
11. ХАр тугалга.	ХТ
12. Титан.	ТТ
13. Цайр.	ЦР
14. Өнгөт төмөрлөгийн холимог хаягдал.	ӨТХХ
15. Хэрэглээний гарсан өнгөт төмөрлөг.	ХГӨТ

1.2 Хоёрдогч түүхий эдийн зориулан бэлтгэх өнгөт төмөрлөгийн хэлбэр байдлаар нь 2-р хүснэгтийн дагуу бэлтгэнэ.

2-р хүснэгт.

Ангилал.	Тэмдэглэгээ.
1. хайлш, хуудас, байдлаар дулаар байгаа	ЦУЛ
2. Зоргодос.	ЗОР
3. Үйрмэг, нунтаг, хэлбэрээр байгаа	НУН
4. Бусад хэлбэрээр.	БУС.

## MNS 3438:83

**1.3** Үйлдвэр аж ахуйн газрууд өнгөт төмөрлөгийн хаягдлыг хоёрдогч түүхий эдэд зориулан бэлтгэж байгаа бол 1.1.1.2-д заасан ангиллаас гадна химийн бүтцээр нь 3-р хүснэгтэнд заасан ангилалд хувааж тэмдэглэсэн байна. Мөн маркаар ангилж түүний тэмдэглэгээг тавьж болно.

3-р хүснэгт.

Ангилал.	Тэмдэглэгээ.
Тухайн төмөрлөг 95 % - иас дээш.	1
----- " ----- 50 - 95 % хүртэл.	2
----- " ----- 50 %- иас дээш.	3

**1.4** хэрэглээнээс гарч буй өнгөт төмөрлөгийн энэ стандартын 1.1-ийн "ХГЭТ" ангилалаар авч тухайн төмөрлөгийн нэрийн ангиллыг нэмж өгнө. Жишээ нь: Хөдөлмөрчдөөс хөнгөн цагаан сав, суулга, авсан бол түүнийг тусад нь ачуулах бөгөөд тэмдэглэгээг "ХГӨТХЦ" гэж тэмдэглэнэ.

**1.5** Бэлтгэж байгаа өнгөт төмөрлөгийн аль болох өөр төрлийн өнгөт болон хар төмөрлөг, бусад хольцоос ялгаж салгасан.

5. Өнгөт төмөрлөгийн MNS 3438-82-ын дагуу 1.5 "бусад хольц 5 %-иас ихгүй байна." Гэсэн "бусад хольц 1 %-иас ихгүй байна." гэж, мөн энэ MNS 2-р хүснэгтийн 1-д байгаа "хайлш" гэснийг "хайлуулсан" гэж тус тус өөрчлөн найруулах. Хэрэв хар төмөрлөгийн хольц 10 %-иас илүү бол нийт жингээр нь хар төмрийн хаягдал хүлээж авна. Харин консервийн лааз, цагаан төмөр зэргийн гангаас цагаан тугалга үнээр авна.

(10 %-иас дээш 20 % хүртлэх) үед төмөрлөгийн хаягдалд хамааруулах түүнээс дээш %-ийг хар төмөрлөгт хамааруулах.

Хэрэв олон төрлийн өнгөт төмөрлөгийн салгаж болшгүй авч байвал энэ стандартын 1.1-ийн ангилалын дагуу хүлээн ач барагцаалсан дундач үнийг төлнө.

**1.6** Онгоц, нисдэг тэрэг, цэргийн зэвсэг зэргийн эд анги болох овор ихтэй төмөрлөгийн 1000x1000x2000 хүртэл мм-ийн хэмжээтэйгээр хэрчиж багасгасан байна.

**1.7** Үйрмэг, нунтаг төмөрлөгт урт нь 3.0 мм-ээс бага ширхэгтэй оруулна.

**1.8** Ачуулах буюу бэлтгэлд нийлүүлэх өнгөт төмөрлөгийн нэг хэсгийн жин 100 кг- аас дээшгүй байна.

## 2 ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ ЖУРАМ

**2.1** Хоёрдогч түүхий эдэд зориулсан өнгөт төмөрлөгийн хүндийн жингээр хүлээн авах бөгөөд партын ачуулна. Ачуулсан партын өнгөт төмөрлөгийн ангилал бүрт нэхэмжлэлийг нэгтгэн бичиж болохгүй.

**2.2** Өнгөт төмөрлөгийн түүний гаднах өнгийн онцлог шинж чанараар танин мэдэж хүлээж авах, бөгөөд шаардлагатай гэж үзвэл бололцоотой байгууллага, химийн болон бусад төрлийн шинжилгээ хийж шалган хүлээн авч болно. Ийм шинжилгээг эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон журам зааврын дагуу хийнэ.

## 3 БАГЛАХ, БООХ, ТЭЭВЭРЛЭХ

**3.1** Нэг ангилалын төмөрлөгийн тээврийн нэг хэрэгсэлээр тээвэрлэж байгаа бол түүнийг ямар нэгэн хайрцаг, савгүйгээр тээвэрлэж болно. 95 %-иас дээш төмөрлөгийн гянтболдын, молибден, титан болон нунтаг төмөрлөгүүдийг зоргодос, жижиг хонгио гэх мэт шигшигдэхгүй уут болон хайрцагт хийж 3.2.т заасан хаяг зүүж тээвэрлэнэ.

**3.2** Овор ихтэй, цул төмөрлөгийн тээврийг нэг хэсгээр тээвэрлэж байгаа бол тус бүрт нь хаяг зүүж тээвэрлэнэ. Хаягт:

- Бэлтгэгч байгууллагын нэр
- Энэхүү MNS-ын дугаар.
- Ангилалын тэмдэглэгээ.
- Бохир жин.
- Цэвэр жин.
- Бэлтгэсэн хүний гарын үсэг.
- Он, сар, өдөр.
- Бэлтгэгдэж байгаа хонгио тэсрэх, дэлбэрэх аюулгүй

**3.3** Хорёдогч түүхий эдэд зориулан бэлтгэсэн өнгөт төмөрлөгийн ангилал, холилдохгүй өөр, төрлийн хольц нэмэгдэхгүй байр, талбайд хадгална.

**3.4** Хоёрдогч түүхий эдэд зориулан бэлтгэсэн өнгөт төмөрлөгийн ангилал холилдохгүй, өөр төрлийн хольц нэмэгдэхгүй байр, талбайд хадгална.

#### **4. ХӨДӨЛМӨР, ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА.**

**4.1** Хоёрдогч түүхий эдэд зориулан бэлтгэж байгаа өнгөт төмөрлөгийн тэсрэх, дэлбэрэх зүйлийг ялгаж салгасан байх бөгөөд хүний эрүүл мэндэд хортой ямар нэгэн бодис, эм урвалж бэлтгэх нийлүүлэгч хариуцан ариутгасан байна. Хүлээн авч байгаа төмөрлөг бүрийг шалгаж авах бөгөөд түүний шалгалт хийж болохгүй.

**4.2** Шингэн буюу хийн бодис агуулагдах битүү савын бөглөөг авч доторхийг нь бүрэн шахсан байх бөгөөд таглаагүй байна. Хэрэв таглаа нь гацсан бол өөр газар нүх гаргасан байна.

**4.3** Хоёрдогч түүхий эдийн журмаар цугларуулсан өнгөт төмөрлөгийн хайлуулж ашиглах үйлдвэр, аж ахуйн газар нь холбогдох мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор урьдчилсан шалгалт хийж, тэсрэх, дэлбэрэх аюулгүй азотаар тогтоосны дараа хайлуулах цехэд шилжүүлнэ.

**4.4** Тэсрэх, дэлбэрэх бодистой түүхий эд авсан тэр нь шалгалтаа илэрсэн нөхцөлд түүнийг тусгайлан хадгалж ажлын 3 өдрийн дотор мэргэжлийн байгууллагын аюулгүй болгосон байна

**4.5** Хоёрдогч түүхий эдийг хүлээн авч хадгалж байгаа байгууллага нь хөдөлмөрийн хамгаалал, аюулгүй техникийн нөхцөлийг бүрэн хангасан байна. Хэрэв мөнгөний агуулга 500 г/ тос, их байхад жиших муруйг байгуулахдаа 50 см<sup>3</sup> давсны хүчлийг нэмж, хольж сэгсэрнэ. Зургаас хүртэл жиших муруйг байгуулна.

**4.5** Шинжилгээний дүнг тооцоолох.

## **MNS 3438:83**

**4.5.1** Мөнгөний агуулгыг дараах томъёогоор тооцоолж, грамм тонноор илэрхийлнэ.

$$Ag = \frac{C \cdot V}{m}$$

Үүнд:

$C$  - жиших муруйгаас олсон дээжийн уусмал дахь мөнгөний концентрац гм / см<sup>3</sup>

$V$  - дээжийн уусмалын эзэлхүүн, см<sup>3</sup>

$m$  - дээжийн жинг, г.

**4.5.2** Зэрэгцээ тодорхойлолтын дүнгийн хоорондох зөрөө нь 2-р хүснэгтээс заасан утгаас хэтэрч болохгүй.

**ТӨГСӨВ.**